



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 28/001

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 13.20 минутанд Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон, компанийн өөрийн байранд болов.

Хуралд : Ч.Амарбаатар 3 323 000 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Мөнхбаяр 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Таван толгой транс ХХК 3 532 125 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл/
Ж.Сарангэрэл 10 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр /
Ж.Энхтунгалаг 25 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Баттогтох 615769 ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэл охин нь/
БИ ДИ СЕК 279 781 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл /

7 750 711 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 77.5 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох М.Отгонбаатар, Ж.Жаргалсайхан нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатар удирдав.

Хурлаар:

0. Компанийн 2021 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
1. Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
2. ТУЗ ийн гишүүдийг сонгох
3. Компанийн өр авлагын тухай хэлэлцэх
4. Их хэмжээний хэлцэл батлах тухай
5. Өрийг хувьцаанд хөрвүүлэх

6. Сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах тухай
7. Тэргүүн ээлжинд худалдан авах эрх олгох тухай
8. Компанийн дүрмийн өөрчлөлт

Зэрэг асуудлыг тус тус хэлэлцэв.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Ю.Батжаргал ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 77.5 % хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 13.40 минутанд эхлэв.

СОНССОН НЬ:

- ✓ Хурлын дарга Ч.Амарбаатар хурлыг нээж үг хэлэв.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд та бүхэнтэй нээлттэй ярилцаж санал бодлоо хуваалцахын зэрэгцээ өнгөрсөн жилд хийсэн ажлын бүтээмж, үйл ажиллагааны болон санхүүгийн талаар дүгнэж санал бодлоо илэрхийлэх бусад хэлэлцэх асуудлын хүрээнд нээлттэй боломж олдож байгаад баяртай байна.

Цаашидаа компанийхаа төлөө тавьсан зорилго зорилгоо хэрэгжүүлж ажиллах үүднээс хамтарч ажиллах, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдалыг бууруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгааг нийт хуралд оролцож буй компаний эрх бүхий албан тушаалтнуудад өөрийн зүгээс байр сууриа илэрхийлэв. Ингээд хурал нээсэнийг мэдэгдэж хурлын дэгийг уншиж танилцуулав.

Тус компанийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ танилцуулах талаар төлөвлөөд байна. Зөвшөөрч байна уу .

- Хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

СОНССОН НЬ:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2021 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг М.Ган-Эрдэнэ товч танилцуулав. Үүнд:

- 2021 оны үйл ажиллагааны товч тайлан

2021 онд “Монгол шилтгээн” ХК нь цар тахлын хөл хорионы улмаас үйл ажиллагаа явуулж чадаагүй зөвхөн зуны 3 сард зуслангийн зориулалтаар цөөн тооны гэрүүдийг түрээслэн хаалттай байдалд ажиллалаа.

Playtime болон бусад шоу наадмууд болоогүй хэрмэн дотор бүтэн цоожтой 2 жил болж байгаа учир бүх байрууд бүрэн элэгдэлд орж дээврүүд нь муудан ус гоожин нурж унасан хүйтэн чийгтэй мөөгөнцөртсөн рестораны гадна ханууд бас нурсан байдалтай байна.

“Монгол шилтгээн” ХК нь шүүхийн шүүхийн шийдвэрээр амралтын цогцолбор 1967 м.кв барилга, 36 000 м.кв газрын хамт Голомт банкны барьцаанд, шийдвэр гүйцэтгэлийн түвшинд компанийг дампууруулах шүүхийн шийдвэрийн дарамтанд байгаагаас шалтгаалан банкны дансууд битүүмжлэгдсэн төрийн байгууллагуудаар үйлчлүүлж өөрчлөлт хийлгэх гэх мэт хөдөлгөөнүүд хаалттай байгаа болно.

Үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамааран жилд үл хөдлөх хөрөнгийн татварт 23.298 930 төгрөг, газрын төлбөрт 16.115 408 төгрөгийн татварын өр тогтмол нэмэгдэн үүсч байдаг.

Одоогийн байдлаар хуримтлагдсан татвар 185 484 651 55 төгрөгийн өглөг үүсчихээд байгаа нь тогтмол 4 улирлын үйл ажиллагаа явуулдаггүй бизнесийн онцлог нь татварын өрийг нэг мөсөн гүйцэт төлөх боломжгүй учраас зуны гурван сардаа үйл ажиллагаа явуулах гэхээр татвар болон бусад төрийн байгууллагуудаас заавал татвар төлсөн байж ажил эхлүүлэх зөвшөөрөл авдаг зэрэг нь бизнесийн хөгжилд хүндрэл учирч байна.

- 2022 оны хувьд компани хэвийн ажиллахын тулд хэрмэн доторхи бүх байруудад дээврээс нь эхлээд бүрэн засвар хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд энэ ажил нь мэдээж маш их хөрөнгө оруулалт шаардана. Нэгэнт ийм их хөрөнгө оруулалт хийх тохиолдолд нэг мөсөн халаалт, усны систем нь шийдэгдсэн 4 улиралд ажиллаж болох шинэ байр барьсан нь дээр байхаар санагдаж байгаа болно.
- Орлого үр дүнгийн тайлан / 2020, 2021 оны харьцуулалт/
Зочид буудлын орлого 2020 онд – 20 848 636 36 төг
2021 онд – 20 797 000 төг
Гэр түрээсийн орлого 2020 онд – 46 272 727 27 төг
2021 онд – 46 272 727 27 төг
Зардалд 2020 онд: 54 806 300 төг
2021 онд 65 412 207 27 төг зардал гаргасан байдалтай байна.

Үйл ажиллагааны чиглэлээр:

- Цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ орлого нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллана.

Барилгад засвар тохижилт үйлчилгээ хийх:

- Барилгын засвар болон дээврийн ажлуудыг хэсэгчлэн хийх
- Үйлчилгээний стандарт харилцаа хандлагын талаарх сэдэвчилсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах

Санхүү мэдээ борлуулалт

- Санхүү нийгмийн даатгалын, татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх

Өр үүссэн шалтгааныг хэлэлцэж, улмаар өрийг хувьцаанд хөрвүүлэх тухай нийт хуралд оролцогчдын саналыг нээлттэй хэлэлцэх шатанд шилжлээ. .

- Хурлын дарга Ч.Амарбаатар

Өрийг хувьцаанд хөрвүүлэх нь компанид ямар ач холбогдолтой байх улмаар өрийг хувьцаагаар солих нь компани өргүй болох улмаар цааш үйл ажиллагаа явуулах компанийн үйл ажиллагаа хэрхэн сэргэх боломжтой талаар тайлбар хийлээ.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Отгонбаатар

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Энэ компанийн өрийг хувьцаагаар солих нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигийг хамгаалсан цаашлаад компани өрнөөсөө гарч компани болон хувьцаа эзэмшигч нарт маш ашигтай шийдвэр юм аа гэдгийг хариуцлагатайгаар дэмжиж хэлэх байна.

Өрийг хувьцаанд хөрвүүлэх талаар товч танилцуулав.

Компанийн тухай хуулийн 62.1.3-д заасны дагуу “компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн компанийн тухай хуулийн 63.7-д “ энэ хуулийн 62.1.1-62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.” Гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд төслийг танилцуулж байна.

Хувьцаанд хөрвүүлэх өрийн дүн-2 500 000 100 төгрөг

Зарласан хувьцаа нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 8 620 690 ширхэг энгийн хувьцаанд хөрвөнө. Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлснээр Монгол шилтгээн ХК нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 18 620 690 ширхэг энгийн хувьцаатай болно.

Өрийг хувьцаагаар солихтой холбоотойгоор СЗХороо нь компанийн өрийг хувьцаагаар сольж нэмж гаргаж буй үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг гаргасанаар компани хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

- Асуулт: Хувьцаа эзэмшигч Таван толгой транс ХХК ийн төлөөлөл Г.Мөнхбилэг асуусан нь:

Өрийг би болон манай компани өөрийн эзэмшдэг хувьцааны хүрээнд энэ хувьцаанд оногдох өрийг төлөөд хувьцаа эзэмших эрхээ нэмэгдүүлж болох уу. Өөрөөр хэлбэл манай компани энэ өрийг бүхэлд нь өрийг төлөөд хувьцаа эзэмшиж болох уу ..

- Хариулт, Тайлбар : ТУЗ-ийн хараат бус гишүүн: Ж.Жаргалсайхан

Өрийг хувьцаагаар солих нь хамгийн зөв шийдвэр юм. Компанид өнөөдөр мөнгө байхгүй. Харин өрийг хувьцаагаар солих нь компани болон хувьцаа эзэмшигчдээс ямар нэг нэмэлт зардал гарахгүй хамгийн оновчтой зөв шийдвэр гэж үзэж байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигийг хамгаалсан ямар нэг байдлаар бусдын эрх ашиг хөндөгдөхгүй юм. Өрийг хувьцаагаар солих шийдвэр гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Өөрөөр хэлбэл: Хувьцаа эзэмшигчдэд компанид хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үүссэн гэж үзэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон болон эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах, хувьцаагаа компанид худалдах эрхтэй. Одоогийн хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьцаа нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл компанийн хувьцаа нэмэгдэж байгаа процесс юм.

- Тайлбар, хариулт Ч.Амарбаатар

Өрийг хувьцаанд хөрвүүлснээр зардал багатай энэ хүнд нөхцөл байдлаас гарах хамгийн оновчтой зөв шийдэл юм аа. Өрийг хувьцаагаар сольсон нь санхүүгийн хувьд өр төлбөргүй болж компанийн үйл ажиллагаа сэргэх маш чухал давуу талуудтай юм. Одоогийн компанийн байдал маш хүнд үйл ажиллагаа зогсонги өр төлбөртэй ямар нэг байдлаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх болоцоогүй ийм нөхцөл байдлууд үүсээд байгаа.

- Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэний үндсэн дээр хуралд оролцсон нийт гишүүд өрийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг дэмжиж хурлаараа хэлэлцэн саналын хуудас бөглөх цаг руу шилжлээ.
- Өрийг хувьцаагаар сольж байгаатай холбоотойгоор Компанийн дүрэмд дараах өөрчлөлт орно. Үүнд: “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 18 620 690 ширхэг энгийн хувьцаатай болох өөрчлөлтийг хэлэлцэн саналын хуудас бөглөх цаг руу шилжлээ.
- Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25%-аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл” хийх нь их хэмжээний хэлцэлд тооцогдоно гэдгийг хэлэлцэн хүлээн зөвшөөрч санал асуулга руу шилжлээ.
- Компанийн 2 500 000 100 төгрөгийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлэх талаарх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хурал хэсэг засварласаны дараа Тооллогын комиссын дарга А.Ариунтунгалаг , гишүүн Ю.Батжаргал нар саналын хуудасыг тоолж танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунсайн хурлаас гарсан шийдвэр, тогтоолын төслийг уншиж танилцуулснаар хурал амжилттай өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:1

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:2

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ч.Амарбаатар
2. М.Ган-Эрдэнэ
3. Г.Ганчимэг
4. Д.Дагвадорж
5. Г.Мөнхбилэг
6. Б.Билгүүн

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Ж.Жаргалсайхан
2. М.Отгонбаатар
3. Д.Чанцал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 3

1. “Монгол шилтгээн” ХК-ийн хуримтлагдсан 2.500.000.100 / хоёр тэрбум,таван зуун сая, нэг зуун мянга/ төгрөгийн өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны үнийг 290 төгрөгөөр тогтоосугай.

2. “Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% - аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл” зэрэг их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:4

1. Компанийн 2.500 000 100 /хоёр тэрбум таван зуун сая нэг зуун мянга/ төгрөгийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсүгэй.
2. Өрийг хувьцаагаар солих төслийг хавсралтаар баталсугай.
3. Компанийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлсүгэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:5

1. Компанийн 2. 500. 000. 100 /хоёр тэрбум, таван зуун сая, нэг зуун мянга / төгрөгийн өрийг хувьцаагаар солихоор нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигч нарт тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг эдлүүлсүгэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :6

2. Компанийн өрийг хувьцаанд хөрвүүлснээр “Монгол шилтгээн” ХК нь нэг бүр нь 290 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 18. 620. 690 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
3. Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн өрийг хувьцаанд хөрвүүлэх шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлсүгэй.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 17 цаг 10 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН



/ А.АРИУНСАЙН /